



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг бууруулах тухай

Дугаар: 2024/02

Огноо: 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөвийг харгалзан үзээд бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 2024 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд 6.4 хувь, Улаанбаатар хотод 6.1 хувьтай гарлаа. Монголбанкнаас 2022 оноос хэрэгжүүлж буй мөнгөний бодлого нь инфляцыг бууруулж, тогтворжуулах нөлөө үзүүлж байна. Түүнчлэн, импортын бараа, бүтээгдэхүүний инфляц саарах хандлага үргэлжилсний зэрэгцээ дотоодын хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт тогтворжсоноор инфляц ийнхүү буурлаа. Цалин, тэтгэврийн өсөлт, төсөв, түүнтэй адилтгах санхүүжилт нь инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй хэдий ч түүний нөлөө хүлээлтээс бага байгаа тул инфляцын богино хугацааны төсөөллөө буурууллаа.

Гадаад эрэлт, экспортын биет хэмжээ өндөр байгаа нь валютын орох урсгал, төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлж байна. Зудын нөхцөл байдлаас шалтгаалан малын зүй бус хорогдол өвлийн саруудад огцом нэмэгдсэн нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, цаашлаад эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Иймд Монголбанкны Мөнгөний бодлогын хороо эдийн засгийн дунд хугацааны тогтвортой өсөлтийг дэмжиж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулахаар шийдвэрлэлээ. Энэхүү бодлогын шийдвэр нь дунд хугацаанд инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилттой нийцтэй болно.

Цаашид эдийн засгийн гадаад, дотоод орчин, инфляцын төлөв хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч бодлогын дараагийн алхмыг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО